## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА ӨЛЗИЙДҮҮРЭНГИЙН ЦОЛМОНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 1 | Олон улсын гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судлаж, боловсруулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ДГБ, ОУВС, НҮБ-ын ХХБХ, Олон улсын худалдааны төв, Монгол Улсын Гадаад худалдааг хөгжүүлэх төсөлтэй хамтран ажиллаж, 13 уулзалт, форум, сургалт зохион байгуулахад оролцож, нийт 127 албан хаагчийг хамруулсан;<br>Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд тус хэлтсээс саналаа тусган ГЕГ-ын албан хаагчдад танилцуулан өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийг орчуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 ажлын хэсэгт | Эхний хагас жилд:<br>1.ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийг орчуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх. | ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичиг, албан бичиг, мэдээ мэдээлэл зэрэг 40 албан захидал 300+ мэйл солилцож, албан бичиг, захидлыг орчуулан ГЕГ-ын удирдлагуудад танилцуулан холбогдох мэдээллийг албан хаагчдад CERP болон СПАРК системээр түгээж байсан.<br>ДГБ бусад олон улсын байгууллагатай хамран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Олон улсын гаалийн өдөр 2025” өдөрлөгийг зохион байгуулж олон нийтийн хуудсаар болон СЕРП-ээр түгээсэн ба 16 албан хаагчид ДГБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Талархлын гэрчилгээ илгээснийг гардуулан олгосон.<br>Олон улсын баримт бичиг судалж боловсруулах ажлын хүрээнд хамтран ажиллагч байгууллагууд руу 4 судалгаа хүргүүлсэн. Үүнд:<br>- Ази номхон далайн бүс нутгийн стратеги төлөвлөгөөний судалгаа 2024/2025; | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | | - Азийн хөгжлийн банк - КАРЕК-н бүс нутгийн хилийн боомтуудын худалдааны бэлэн байдлын үнэлгээний судалгаа;<br>- WCO-RILO/AP- Ази Номхон далайн бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцох албаны Гишүүн орны гаалийн байгууллагуудаас үйл ажиллагааны санал хүсэлт, холбогдох судалгаа;<br>- ДГБ-ын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны зөвлөмжийг шинэчлэх судалгаа.<br>ДГБ-ын Тариф, Худалдааны Газраас 2025.05.19-23-ны өдрүүдэд ГЕГ-т зохион байгуулагдсан “Барааны ангилал, Барааны ангиллын урьдчилсан шийдвэр ” сэдэвт ашиглагдсан сургалтын гарын авлагуудыг орчуулж, сургалтын үеэр сургалтад хамрагдсан 26 албан хаагчдыг мэдээллээр хангаж, чадавхжуулах чиглэлд ажилласан. | | |
| 2 | Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Хамтын ажиллагааны арга хэмжээг (Хөрш орнууд) өндөр түвшинд зохион байгуулах гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөр гаалийн байгууллагын үйл ажилаагаанд хэрэгжиж, үр дүнгээ өгөх ажлын хүрээнд:<br>**ОХУ-ын ХГА-тай**:<br>- ИААН харилцан хүлээн зөвшөөрөх тухай монгол улсын ГЕГ болон ОХУ-ын ХГА хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлаарх шинжээчдийн анхдугаар уулзалт уулзалтыг зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу хоёр талын мэдээлэл солилцон ажиллаж байна.<br>- “Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай” монгол-оросын 2023 оны хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлаарх | 1. Хөрш орнуудын гаалийн байгууллагатай өндөр түвшинд зохион байгуулах гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөр гаалийн байгууллагын үйл ажилаагаанд хэрэгжиж, үр дүнгээ өгөх.<br>2. Гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийг хийх чиглэлээр БНХАУ-тай санал солилцох. | **1. ОХУ-ын ХГА-тай** холбоо барьж цахим шууданграар 154 удаа албан бичиг мэдээлэл солилцон ажилласан.<br>Экспортын мэдүүлэг солилцох чиглэлээр мэдээллийн технологийн шинжээч нарын уулзалтыг амжилттай зохион байгуулж үүний үр дүнд 54 нэр төрлийн барааны экспортыг монгол-оросын гаалийн байгууллага хооронд солилцон гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Хилийн гаалийн холбоо баригч дарга нарын уулзалт болон Зөрчилтэй тэмцэх хүрээнд хийгдэг 2 талын уулзалт ажлын давхацсан байдал болон санхүүгийн хүндрэлээс шалтгаалан хойшилсон ба Зөрчилтэй тэмцэх хүрээнд хийгдэх уулзалтыг энэ оны 07 сарын 01-03-ны хооронд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>**2. БНХАУ-ын ГЕГ-тай** цахим шуудан болон вечат-аар 150+ албан бичгээр мэдээлэл солилцон ажилласан. Гадаад худалдааны 2024 оны статистик зэрэгцүүлэлтийн мэдээг цахимаар хүргүүлсэн бөгөөд | 2025.01.01 - 2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжээчдийн анхдугаар уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны төлөвлөөг баталсан. | | статистик зэрэгцүүлэлт хийх чиглэлээр БНХАУ-тай санал солилцсон боловч хятадын талаас дэмжих санал ирээгүй. (Хавсралттай) | | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 3 | Албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулж мэргэшлийн мэдлэгийг дэшлүүлэх зорилгоор ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран цахим болон биет хэлбэрээр нийт 45 арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд:<br>Уулзалт, хурал (31): Нийт 104 албан хаагч;<br>Сургалт (12): Нийт 34 албан хаагч;<br>Үндэсний (2): Нийт 73 албан хаагч.<br>Энэ нь зорилтот түвшингээс 55,5 % илүү байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 9,5% нэмэгдсэн байна.<br>Албан хаагчдын уулзалт, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөхөд дэмжлэг болгох үүднээс гадаад уулзалт, сургалтын тайланг ЗДС програмд байршуулж (Хандалт: 832; Тайлан, үр дүнгийн хэрэгжилт: 90 орчим %) нийтэд танилцуулж байгаа | Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулах, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөх. Үүнд:<br>Уулзалт- 10;<br>Сургалт- 10. | Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулж мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран цахим болон биет хэлбэрээр нийт 26 арга хэмжээ зохион байгуулж 95 албан хаагчийг хамруулсан ба зорилтот түвшингээс 30 % илүү байна.<br>Үүнд: Уулзалт, хурал (11): Нийт 26 албан хаагч;<br>Сургалт (14): Нийт 41 албан хаагч;<br>Үндэсний (1): Нийт 28 албан хаагч.<br>Энэ нь зорилтот түвшингээс илүү боловч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хамрагдсан албан хаагч 8% буурч арга хэмжээний тоо 43% буурсан. Энэ нь бусад орны улс төрийн бодлогоос хамаарч зарим гадаад арга хэмжээ цуцлагдсантай холбоотой.<br>Албан хаагчдын уулзалт, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөхөд дэмжлэг болгох үүднээс гадаад уулзалт, сургалтын тайланг ЗДС програмд байршуулж (Хандалт: 1411; Тайлан, үр дүнгийн хэрэгжилт: 98,3%) нийтэд танилцуулж байгаа бөгөөд ЗУГ-аас зохион байгуулж байгаа албан хаагчдын мэдээллийн цагаар гадаад арга хэмжээний үр дүн, тайланг нийт албан хаагчдад танилцуулж байгаа нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглахад дэмжлэг болж байгаа юм. | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бөгөөд ЗУГ-аас зохион байгуулж байгаа албан хаагчдын мэдээллийн цагаар гадаад арга хэмжээний үр дүн, тайланг нийт албан хаагчдад танилцуулж байгаа нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглахад дэмжлэг болж байгаа юм. | | Тайлангийн хэрэгжилт, цар хүрээ өмнөх оны мөн үетэй харьцуулбал хандалтын тоо 41,03%-р, хэрэгжилт 8% өссөн үр дүнтэй байна. | | |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 4 | Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, КАРЕК, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Австрали, Тайван болон бусад орны гаалийн байгууллагатай хамтран ажиллаж 250 гаруй цахим захидал соилцож биет хэлбэрээр хурал уулзалт зохион байгуулж гаалийн байгууллагын тулгамдсан асуудал, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тухайн улсуудад 19 хурал, уулзалт, сургалтад 37 албан хаагчыг хамруулсан. Түүнчлэн холбоо барьж ажилласаны үр дүнд:<br>- ДГБ-ын Гарал үүсэл үндэсний семинар, ОУВС-ийн "Мөнгө угаахтай тэмцэх" зорилгоор зохион байгуулж буй үндэсний семинарыг Монгол Улсад зохион байгуулан 68 албан хаагч;<br>- ДГБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн гаалийн байгууллагын дарга нарын 25 дахь удаагийн хуралд ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал оролцон монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилж | Эхний хагас жилд: Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилж, гаалийн асуудлаар холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажиллана. | 1. Холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлын хүрээнд:<br>- *ОХУ-ын ХГА-тай* цахим шуудангаар 154 албан бичиг, edoc програмаар 57 албан тоотыг оросын талд илгээж 48 дотоод зурвасыг байгууллага хооронд илгээсэн.<br>- *БНХАУ-ын ГЕГ-тай* цахим шуудан болон вечат-аар 150+ албан бичиг, edoc програмаар 23 албан тоотыг хятадын талд илгээж 21 дотоод зурвасыг байгууллага хооронд илгээсэн.<br>- ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, КАРЕК, АНУ, Япон, БНСУ, Австрали, Хонгкок 300+ гаруй цахим захидлаар холбоо барьж ажилласан бөгөөд 16 албан бичиг бусад орны гаалийн байгууллагад хүргүүлсэн байна.<br>2. Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилж ажилласны үр дүнд:<br>- ДГБ-тай хамтран "Барааны ангилал, Барааны ангиллын урьдчилсан шийдвэр" сургалтыг ГЕГ-т зохион байгуулан 28 албан хаагчийг сургасан.<br>- МУ-ын ГЕГ болон БНХАУ-ын ГЕГ хоорондын ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр 2025.06.01-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэн.<br>- БНХАУ-ын Итгэмжлэлийн Газраас (CNAS) ISO/IEC 17025 чанарын стандартын хяналтыг 2025.04.18-21-ний | 2025.01.01 - 2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон. | | өдрүүдэд Гаалийн Төв Лабораторид хийлгэж итгэмжлэл авсан.<br>- Зохион байгуулагч талын зардлаар 22 арга хэмжээнд 54 албан хаагчийг 11 оронд сургалт, уулзалтад хамруулсан. | | |
| 5 | Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад 13 арга хэмжээ зохион байгуулж үүнээс 11 уулзалт, үндэсний хэмжээний 2 сургалт зохион байгуулж 140 албан хаагч хамруулсан. Дээрх арга хэмжээг зохион байгуулах хүрээнд 24 презинтаци, 100 гаруй хуудас материал (Үүнд: хурал даргалагчийн үг, ярианы сэдэв, уулзалтын тэмдэглэл, протокол г.м) орчуулсан. Үүнд:<br>- ИААН харилцан хүлээн зөвшөөрөх монгол-оросын хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх шинжээчдийн анхдугаар уулзалт;<br>- ОУВС-ийн Азийн гаалийн байгууллагын шинэчлэлийн хөтөлбөр;<br>- ДГБ-ын Гарал үүсэл үндэсний семинар;<br>- ОУВС-ийн “Мөнгө угаахтай тэмцэх” асуудлаар зохион байгуулж буй үндэсний семинар;<br>- Монгол улсын ноос ноолуур малын гаралтай техникийн зориулалтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд үнэлгээ хийх хөтөлбөр;<br>- “Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай” монгол-оросын хэлэлцээрийг хэрэгжүүлэх | Эхний хагас жилд: Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулж, орчуулгын талаар оновчтой тайлагнах. | 1. Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулах хүрээнд:<br>Хөрш орнууд, ДГБ, ОУВС, НҮБ-ын Ази номхон далайн эдийн засаг нийгмийн комисс, Карек, Ази Номхон далайн бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцох алба зэрэг байгууллагуудаас цахим хэлбэрээр ирүүлсэн гаалийн хэргийн чиглэлийн 260 гаруй хуудас бүхий 90+ албан бичиг болон 4 баримт бичиг 29 хуудас (КАРЕК-н бүс нутгийн хилийн боомтуудын худалдааны бэлэн байдлын үнэлгээний судалгаа; Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай МУ-ын ЗГ, Туркменистан Улсын ЗГ хоорондын хэлэлцээр; Зөрчилтэй тэмцэх газар болон ОХУ-ын ХГА-ны Сибирийн болон Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газар хоорондын ажлын 8 дугаар уулзалтын Протоколын төсөл, ОХУ-ын ХГА-тай байгуулах ИИАН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийн төсөл)-ыг англи, орос, хятад хэлнээс монгол хэлнээ орчуулан тухай бүр удирдлагад танилцуулж чиглэл авч ажилласан.<br>Эдгээр албан бичгийн дийлэнх уулзалт, сургалт; ДГБ-аас батлан гаргасан бодлогын баримт бичиг, цаг үеийн шинжтэй зөвлөмж чиглэл, санал асуулга эзэлсэн.<br>2. Монгол Улсад 5 арга хэмжээ зохион байгуулж хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийсэн. Үүнд:<br>- ГЕГ-ын даргын АНУ-ын ЭСЯ болон ОХУ-ын ЭСЯ-ны цэргийн атташе нартай хийсэн 3 уулзалт; | 2025.01.01 - 2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудлаарх шинжээчдийн анхдугаар уулзалт;<br>- UNDP дэмжлэгтэй Их түмэн санаачлага (GTI) Гаалийн дэд хорооны 6-р уулзалт;<br>- НҮБ-ын Хар тамхи, гэмт хэргэтэй тэмцэх чиглэлийн уулзалт;<br>- Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооны 6-р уулзалт;<br>- КАРЕК-ийн ИААН-ийн үндэсний семинар;<br>- Монгол, Оросын ЗГХК-ын 25 дугаар хуралдаан болон Монгол, Хятадын ЗГХК-ын 17 дугаар хуралдаан. | | - БНХАУ-ын Итгэмжлэлийн Газраас Гаалийн Төв Лабораторид хийсэн (CNAS) ISO/IEC 17025 чанарын стандартын хяналт (3 өдөр);<br>- БНСУ-ын Консорциумаас хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх төсөл болон ГЕГ-ын ЭУХ хоорондын уулзалт. | | |
| 6 | ДГБ бусад олон улсын байгуулагтай хамран ажиллаж, гаалийн байгуулагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ДГБ бусад олон улсын байгуулагатай хамран ажиллаж, гаалийн байгуулагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Олон улсын гаалийн өдөр 2024” өдөрлөгийг зохион байгуулсан. Энэ нь ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 10 чиглэлээр цахим гарын авлага, видео, постер, брошураар гаалийн байгууллагын хамт олонд, цахим, цаас, олон нийтийн хуудсаар түгээсэн. Үүний үр дүнд гаалийн байгууллагын мэдээллийн цагаар гадаад арга хэмжээний мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, хамрагдсан албан хаагч нар гаалийн байгуулагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулж, үйл ажилаагаандаа нэвтрүүлж | Эхний хагас жилд: ДГБ болон бусад олон улсын байгууллагатай (ДГБ, НҮБ, ОУВС, Их түмэн санаачилга, КАРЕК гэх мэт) хамтран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна | ДГБ бусад олон улсын байгууллагатай хамран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Олон улсын гаалийн өдөр 2025” өдөрлөгийг зохион байгуулсан. Энэ нь ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 10 чиглэлээр цахим гарын авлага, видео, постер, брошураар гаалийн байгууллагын хамт олонд, цахим, цаас, олон нийтийн хуудсаар түгээсэн.<br>Үүний үр дүнд гаалийн байгууллагын мэдээллийн цагаар гадаад арга хэмжээний мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, хамрагдсан албан хаагч нар гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж нийтэд мэдээлэн хуваалцдаг болсон. ЗДС програмаар гэлтгүй илтгэл хэлбэрээр мэдээлэл түгээж байгаа нь үр дүнг тодорхой болгож, томилолтын тайланг тухай бүр хүргүүлэхэд дэмжлэг болсон байна. Гадаад арга хэмжээнд оролцсон албан хаагчид тайлангаа хугацаанд нь ирүүлдэггүй байсан бол энэ оны эхний | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийтэд мэдээллэн хуваалцдаг болсон. ЗДС програмаар гэлтгүй илтгэл хэлбэрээр мэдээлэл түгээж байгаа нь үр дүнг тодорхой болгож, томилолтын тайланг тухай бүр хүргүүлэхэд дэмжлэг болсон байна. Гадаад арга хэмжээнд оролцсон албан хаагчид тайлангаа хугацаанд нь ирүүлдэггүй байсан бол энэ оны эхний хагас жилд 90% ирүүлсэн нь мөн оны үетэй харьцуулвал тайланг 11% илүү хүргүүлсэн байна. | | хагас жилд 98%-ийн биелэлттэй буюу 22 арга хэмжээнээс 21 арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн байна. | | |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ГЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг хангаН 2024.06.20 –ны өдөр тайлагнасан. Мөн тушаалын 2.5.8-ийн дагуу гадаад улсад зохион байгуулагдсан 19 хурал, уулзалт, сургалтад зохион байгуулагч талын зардлын тусламжаар 37 албан хаагчыг хамруулсан.<br>Түүнчлэн А/190 дүгээр тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 10 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудасаар дамжуулан олны | Эхний хагас жилд : Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. | ГЕГ-ын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан 12 шалгуур үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг хангаН 2025.06.10 –ны өдөр CERP системээр хугацаанд нь илгээж 100% тайлагнасан. Мөн тушаалын 2.5.8-ийн дагуу гадаад улсад зохион байгуулагдсан 22 хурал, уулзалт, сургалтад зохион байгуулагч талын зардлын тусламжаар 54 албан хаагчийг хамруулсан. Мөн оны эн үетэй харьцуулбал арга хэмжээ 13%-р өсөж, албан хаагчдын тоо 31,4% өссөн байна.<br>Түүнчлэн А/190 дүгээр тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 3 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан олны хүртээл болгосон.<br>ГЕГ-ын даргын 2023 оны А/675 тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчид олгох мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай", ГЕГ-ын даргын 2024 оны А/204 | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | | хүртээл болгон, ил тод, нээлттэй байдлыг хангасан. Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг тус хэлтсийн албан хаагчдад танилцуулж, загвар хүснэгтийн дагуу гарын үсгээр баталгаажуулан Тус нэгжийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр ДГБ болон бусад олон улсын байгууллагын гэрээ, конвенцийн хэрэгжилт бусад орны гаалийн байгууллагатай гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах Засгийн газрын хэлэлцээрт үндэслэн гаалийн асуудлаар мэдээлэл солилцож, хамтын ажиллагааг хөгжүүлж ажилласан (250 гаруй цахим захидал солилцсон). | | тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчийн улирлын ажлын үр дүнгийн шалгуур, мөнгөн урамшууллын хэмжээг тогтоох тухай" тушаалын дагуу ажилтан, албан хаагчдын ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн үнэлгээний хуудсыг сар бүрийн 05-ний дотор хүргүүлж хэвшсэн. | | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжих, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | ГЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан 12 шалгуур үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг хангаң | Эхний хагас жилд: Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын | ГЕГ-ын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын 1.10 дугаар хавсралтаар баталсан 12 шалгуур үзүүлэлтийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган 2025.06.10 –ны өдөр CERP системээр хугацаанд нь илгээж 100% тайлагнасан. | 2025.01.01 - 2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2024.06.20 –ны өдөр CERP системээр хугацаанд нь илгээж 100% тайлагнасан.<br>ХАСХОМ-ыг 2024 оны тайланг хуулийн хугацаанд ажиллаж байсан 4 албан хаагч 100 хувь баталгаажуулсан. ХАСУМ-ийг шилжин ажиллах 1 албан хаагч мэдүүлж баталгаажуулсан.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хэлтсийн чиг үүргийн хүрээнд нийт 134 гадаад, 49 дотоод албан бичиг, 124 дотоод зурвасыг хүлээн авч, нийт 307 бичгийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн. Энэ нь мөн онтой харьцуулвал 6,5% илүү албан бичгийг шийдвэрлэсэн байна. | баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна. | ХАСХОМ-ыг 2024 оны тайланг хуулийн хугацаанд ажиллаж байсан 5 албан хаагч холбогдох баталгааны маягтын дагуу гарган ХНХ-т хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хэлтсийн чиг үүргийн хүрээнд:<br>edoc системээр ирсэн бичиг: 284; явсан бичиг: 423. (үүнээс дотоод зурвас: ирсэн 227; явсан 108).<br>Гадаад орны гаалийн байгууллагатай цахим шуудангаар 780+ гаруй цахим захидал солилцон ажилласан бөгөөд хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн.<br>Энэ нь мөн оны энэ үетэй харьцуулбал 27,4% илүү албан бичгийг шийдвэрлэсэн байна. | | |
| 9 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх зорилгоор судалгаа хийж нэгжийн эрсдэлийн сан үүсгэсэн.<br>Санд доорх хэсгийг тусгасан:<br>–Хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүргийн харьцуулалт;<br>–Үндсэн ажлаас гадуур болон цаг үеийн шинжтэй гүйцэтгэсэн ажлыг тайлагнах;<br>–Ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа албан хаагчдын үндсэн мэргэжил, ур чадвар, гүйцэтгэл, ажлын цаг ашиглалт, илүү цаг болон бусад дотоод ажлыг хөгжүүлэх; | Эхний хагас жилд:<br>- Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэнэ.<br><br>- Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч тайлагнана | 1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэсэн. Үүний үр дүнд:<br>- Тус нэгжийн үндсэн чиг үүрэг гаалийн байгууллагын олон чиг үүрэгтэй хамтын ажиллагааны хэрэгжилттэй уялдах тул дотоод, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл өндөртэй байгаа нь тогтоогдсон.<br>- Хүний нөөцийн хомсдолын улмаас 1 албан хаагч олон давхар ажил хариуцан ажиллаж байгаа нь ажлаас хашрах эмгэг үүсгэж байна.<br>- Албан хаагч нарын Ажил-Амьдралын тэнцвэрийг хангахын тулд ажил үүргийн хуваарийг уян хатан байдлаар өөрчлөх саналтай байна. Тус нэгж нь ихэнх тохиолдолд европын цагаар буюу гадаад орны гаалийн байгууллагатай идэвхтэй холбоо барихын тулд ажлын бус цагаар ажилдаг бөгөөд гадаадын зочид төлөөлөгчдийг шөнөөр тосох хүргэж өгөх зэрэг нойргүй ажилласны дараа тогтоосон цагт цаг бүртгэх төхөөрөмжид | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, гадаад орны гаалийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.<br>2. Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авсан:<br>Нэгжийн эрсдэлийг таньж тогтоох сан үүсгэсэн.<br>Хүний нөөц, бүтэц, зохион байгуулалтад мониторнг хийсэн;<br>Сүүлийн 3 жилд ажлын холбогдолтой үүссэн эрсдэлийг таньж тогтоосон;<br>Ганцаарчилсан болон фокус ярилцлага хийсэн, Цаашдын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг гаргасан. | | бүртгүүлж чадахгүй байгаатай холбоотой юм.<br>2. Эрсдэлийн дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээний хүрээнд:<br>- Гадаад хурал уулзалтын тов гарахаас өмнө ЗББНДБ-аас тухайн нэгжийн үүрэг чиглэлийн дагуу холбогдох материалыг ирүүлэх тухай бичиг илгээж байна. Энэ нь албан хаагчдыг бэлтгэх үгийн санг баяжуулах зорилготой.<br>- Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулах, учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулахад анхаарал хандуулж ажлын бүтээмжийг тухай бүр тайлагнаж хэвшээд байна. | | |
| 10 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр хангон ажиллаж, тайлагнасан. Нэгжийн 2024 оны эхний хагас жилийн үнэлгээ 5. | Эхний хагас жилд:<br>- Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.<br>- Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | Тайлант хугацаанд гадаад: 110, дотоод edoc: 284 албан бичиг хүлээн авч ЗББНДБ-д 108 дотоод зурвас хүргүүлж 227 дотоод зурвасын хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэсэн.<br>Удирдлагаас ЗДАС программаар ирүүлсэн 12 үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж тухай бүр тайлагнан ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 2 үүрэг даалгавар илүү байсан. Үүнд:<br>- Гадаад сургалт, албан томилолтод хамрагдсан албан хаагчдаар сайн туршлагыг түгээлгэх, үр дүнг тооцох ажлыг ЗУГ-тай хамтран хэрэгжүүлсэн.<br>- Төлөвлөлтийг сар, улирал, хагас, бүтэн жил гэсэн үечлэлээр шинээр батлагдах 2025-2028 оны Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан гүйцэтгэлд анхаарч ажилласан. | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ГЕГ-ын даргын 2023 оны А/675 тушаал болон 2024 оны А/204 тушаалын дагуу ажилтан, албан хаагчдын ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэн үнэлгээний хуудсыг сар бүрийн 05-ны дотор ирүүлж хэвшсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 7.2.5, 7.2.6-д заасан шаардлагын дагуу ангилан төрөлжүүлж архивт хүлээлгэн өгсөн. | | |
| 11 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | Нэгжийн албан хаагчдын цаг ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байна.<br>Нэгжийн 2024 оны эхний хагас жилийн үнэлгээ 4.1 | Эхний хагас жилд : Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна. | Хэлтсийн чиг үүрэгтэй уялдуулан гадагш томилолтоор ажиллах, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах зэрэг шалтгаанаар цаг бүртгэлийн системд өдөр бүр бүртгүүлэх боломжгүй байна. Томилолт, чөлөөний мэдэгдлийг тухай бүр CERP системээр бүртгүүлж ажиллаж байна.<br>2025 оны 06 дугээр сарын 10-ны байдлаар тус хэлтэс 111 хүн/өдөр батлагдсан 8 албан хаагчийн ажиллах орон тоотойгоор 888 хүн/өдөр байснаас 3 албан хаагчийн сул оронтоотой, ажиллавал зохих 555 хүн өдрөөс ажилласан 555 хүн өдөр байна.<br>Орон тооны хомсдолын улмаас 8 албан хаагчийн үүргийг 5 албан хаагч гүйцэтгэж байгаа нь ажлын ачаалал, давхардалыг үүсгэж байна. Иймд ажлын ачааллыг харгалзан Ажлын цаг ашиглалт 100% гэж дүгнэж байна. | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй 10 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудасаар дамжуулан олны хүртээл болгон, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлсэн.<br><br>ИТС-ын, ОУВС, ДГБ-ын 3 төрлийн төсөлд монголын | Эхний хагас жилд : Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй 10 мэдээллийг бэлтгэн (англи, монгол хэлнээ хөрвүүлэх), цахим хуудаст нийтлэн олны хүртээл болгох ба гаалийн чиг үүрэгтэй | Гаалийн байгууллагын цаг үеийн шинжтэй 3 мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан олны хүртээл болгон, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлсэн. Бусад орны улс төрийн бодлого болон санхүүгийн асуудлаас хамааран монгол улсад зохион байгуулахаар төлөвлөсөн ихэнх гадаад арга хэмжээ зохион байгуулагдаагүйн улмаас цаг үеийн шинжтэй мэдээлэл цөөн байсан. | 2025.01.01<br>-<br>2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаалийн байгууллагын саналыг тусгаж хүргүүлсэн (20 хуудас).<br><br>ГЕГ-ын албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг 70 албан хаагчдад гаргаж өгч гадаад улсын ЭСЯ-нд хүргүүлсэн. | холбоотой санал асуулга, холбогдох судалгаанд хариу хүргүүлэн ажилласан байна. | Гаалийн чиг үүрэгтэй холбоотой 4 санал асуулга, холбогдох судалгаанд хариу *хүргүүлсэн. Үүнд:*<br>- Ази номхон далайн бүс нутгийн стратеги төлөвлөгөөний судалгаа 2024/2025;<br>- Азийн хөгжлийн банк - КАРЕК-н бүс нутгийн хилийн боомтуудын худалдааны бэлэн байдлын үнэлгээний судалгаа;<br>- WCO-RILO/AP- Ази Номхон далайн бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцох албаны Гишүүн орны гаалийн байгууллагуудаас үйл ажиллагааны санал хүсэлт, холбогдох судалгаа;<br>- ДГБ-ын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны зөвлөмжийг шинэчлэх судалгаа.<br>ГЕГ-ын албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг 208 албан хаагчдад гаргаж өгч гадаад улсын ЭСЯ-нд хүргүүлсэн.<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 46 лавлагаа, хүсэлтэд гаалийн хууль тогтоомжийн хүрээнд болон чиглэл хариуцсан нэгжээс мэдээлэл авч тухай бүр хүргүүлэн ажилласан. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | - | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын (UNESCAP) Бизнесийн дүн шинжилгээний BPA онлайн сургалтад хамрагдаж 8 модуль үзэж мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлсэн. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлана. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бие дааж уншиж судалсан байна. | Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцаж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахын тулд ДГБ-ын вебсайт https://www.wcoomd.org/ болон фэйсбүүк пэйж хуудсаар тогтмол зочилж сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлтэй байнга танилцаж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хэлтсийн албан хаагч нарыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган.<br>Түүнчлэн "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Туркменистан Улсын Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар Хоорондын Хэлэлцээр"-ийн төслийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулж бусад Засгийн Газар хоорондын хэлэлцээрийг судалсан. | 01.01-06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гадаад хамтын
ажиллагааны хэлтсийн дарга..................... / Ө.ЦОЛМОН / 2025. 06. 10

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)

# ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА ӨЛЗИЙДҮҮРЭНГИЙН ЦОЛМОНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 58,5 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдах | | 13,5 |
| 2. | Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлах | | 13,5 |
| | **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | 13,5 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 13 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 12 |
| 6. | Харилцаа | 14 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| | **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | 12 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 58,5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13,5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 12 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | – |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 84 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2025.06.25 .......... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Гадаад хамтын ажиллагааны хэлтэсийн дарга ........................ (Ө.Цолмон)

2025.06.10 .......... (огноо)